



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/11/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас: 70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Аудитор: Л.Галбадрах
Утас: 99084291
цахим хаяг: L.Galbadrah@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	12
3.5.3 Нэмэлт төсөв.....	12
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	13
4.1 Ерөнхий зүйл.....	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



ХОВД АЙМАГ ДАХЬ

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд

Утас: 976-70433061, Факс: 976-70433061

E-mail: khovd@audit.gov.mn

2023.01.30 № 02/02
танай _____-ны № _____-т

ХОВД АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Ц.ДЭЛГЭР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт онцлох ажил гүйлгээ байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 701.8-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчид хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,454,225.00	13,633,225.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	2,400,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	2,400,000.00
3121	Төгрөг	00.00	2,400,000.00
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	00.00	2,400,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,454,225.00	11,233,225.00
354	Хангамжийн материал	12,454,225.00	11,233,225.00
35410	Бичиг хэргийн материал	215,000.00	135,000.00
35420	Аж ахуйн материал	2,686,600.00	2,901,600.00
35440	Түлш, шатах тослох материал	5,304,000.00	4,500,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,248,625.00	3,696,625.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	623,757,317.48	593,248,430.61
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	623,757,317.48	593,248,430.61
392	Биет хөрөнгө	617,684,717.48	587,175,830.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	527,969,913.70	527,969,913.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-43,746,237.48	-56,760,948.72
39203	Авто-тээврийн хэрэгсэл	139,000,000.00	139,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-80,444,444.44	-90,777,777.76
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	161,565,919.40	167,577,419.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-130,975,792.36	-140,285,821.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	47,519,990.00	47,919,990.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,624,019.00	-35,098,843.75
39214	Бусад үндсэн хөрөнгө	36,454,650.50	36,454,650.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,827,894.84	-9,805,383.72
39217	Ном	792,632.00	982,632.00
393	Биет бус хөрөнгө	6,072,600.00	6,072,600.00
39301	Програм хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,050,000.00	-1,050,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	6,072,600.00	6,072,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	636,211,542.48	606,881,655.61
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	636,205,370.48	606,881,655.61
51	Засгийн газрын хувь оролцоо	636,205,370.48	606,881,655.61
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	781,939,208.88	781,939,208.88
51101	Өмч: - төрийн	781,939,208.88	781,939,208.88
512	Хуримтлагдсан үр дүн	-167,622,173.07	-196,945,887.94
51210	Өмнөх үеийн үр дүн	-167,622,173.07	-167,622,173.07
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-29,323,714.87
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	21,888,334.67	21,888,334.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	636,211,542.48	606,881,655.61

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	586,396,320.00	608,135,850.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,533,020.00	6,534,250.00

120	Нийтлэг татварын бус орлого	74,533,020.00	6,534,250.00
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/		
120012	Эрхийн шимтгэлийн орлого /ТӨҮГ/		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	511,863,300.00	601,601,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	511,863,300.00	601,601,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	511,863,300.00	601,601,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	529,157,466.58	637,459,564.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	529,157,466.58	637,459,564.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	514,955,228.70	630,929,769.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,851,043.00	453,976,098.00
210101	Үндсэн цалин	266,566,314.00	306,617,771.00
210102	Нэмэгдэл	67,207,935.00	112,398,801.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,119,733.00	13,851,666.00
210104	Урамшуулал	21,957,061.00	21,107,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,937,146.12	56,668,118.00
210201	Тэтгэврийн даатгал	33,149,424.08	38,534,087.90
210202	Тэтгэмжийн даатгал	3,696,930.26	4,533,656.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,957,543.21	3,626,945.50
210204	Ажилгүйдлийн даатгал	739,388.05	906,711.45
210205	Эрүүл мэндийн даатгал	7,393,860.52	9,066,716.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,381,604.00	18,071,571.00
210301	Гэрэл, цахилгаан	4,166,604.00	4,067,571.00
210302	Түлш, халаалт	8,215,000.00	12,804,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,299,813.00	42,406,910.00
210401	Бичиг хэрэг	5,805,000.00	8,314,500.00
210402	Тээвэр, шатахуун	13,366,870.00	14,179,154.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,008,947.00	13,529,106.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	560,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,278,700.00	5,823,550.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,260,660.00	14,267,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,481,300.00	6,632,500.00
210604	Урсгал засвар	10,779,360.00	7,635,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,726,450.00	5,609,000.00
210702	Дотоод албан томилолт	3,726,450.00	5,609,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,175,708.00	2,820,186.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,350,840.00	1,278,140.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,439,850.00	1,378,546.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,500.00	67,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	33,518.00	52,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,822,804.58	37,110,386.87
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,822,804.58	37,110,386.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,202,237.88	6,529,795.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,785,000.00	1,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,785,000.00	1,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,417,237.88	4,929,795.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,417,237.88	4,929,795.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	57,238,853.43	-29,323,714.87
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	57,238,853.43	-29,323,714.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	511,863,300.00	605,601,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	4,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	4,000,000.00
120009	Бусад орлого	00.00	4,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	511,863,300.00	601,601,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	511,863,300.00	601,601,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	511,863,300.00	601,601,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	500,123,960.00	602,334,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	500,123,960.00	602,334,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	487,706,722.12	595,804,305.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	368,853,043.00	453,976,098.00
210101	Үндсэн цалин	266,568,314.00	306,617,771.00
210102	Нэмэгдэл	67,207,935.00	112,398,801.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,119,733.00	13,851,666.00
210104	Урамшуулал	21,957,061.00	21,107,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,937,146.12	56,668,118.00
210201	Тэтгэврийн даатгал	33,149,424.08	38,534,087.90
210202	Тэтгэмжийн даатгал	3,696,930.26	4,533,656.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,957,543.21	3,626,945.50
210204	Ажилгүйдлийн даатгал	739,388.05	906,711.45
210205	Эрүүл мэндийн даатгал	7,393,860.52	9,066,716.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,270,604.00	17,267,571.00
210301	Гэрэл, цахилгаан	4,166,604.00	4,067,571.00
210302	Түлш, халаалт	12,104,000.00	12,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,982,517.00	40,824,660.00
210401	Бичиг хэрэг	5,608,000.00	8,234,500.00
210402	Тээвэр, шатахуун	13,366,870.00	14,179,154.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,008,947.00	13,529,106.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	560,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,278,700.00	4,321,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,260,660.00	14,632,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,481,300.00	6,632,500.00
210604	Урсгал засвар	10,779,360.00	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	3,726,450.00	5,609,000.00
210702	Дотоод албан томилолт	3,726,450.00	5,609,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,176,302.00	2,826,358.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,351,434.00	1,284,312.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,439,850.00	1,378,546.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,500.00	67,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	44,000.00
210807	Газрын төлбөр	33,518.00	52,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,417,237.88	6,529,795.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,600,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,600,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,417,237.88	4,929,795.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,417,237.88	4,929,795.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	11,739,340.00	3,267,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,739,340.00	867,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,739,340.00	867,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,739,340.00	867,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,739,340.00	867,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-11,739,340.00	-867,500.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	2,400,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.01	2,400,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,939,208.88	21,888,334.67	-202,441,193.98	601,386,349.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	781,939,208.88	21,888,334.67	-202,441,193.98	601,386,349.57
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-6,923,998.99	-6,923,998.99
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,939,208.88	21,888,334.67	-167,622,173.07	636,205,370.48
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,939,208.88	21,888,334.67	-167,622,173.07	636,205,370.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	781,939,208.88	21,888,334.67	-167,622,173.07	636,205,370.48
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-29,323,714.87	-29,323,714.87
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	781,939,208.88	21,888,334.67	-196,945,887.94	606,881,655.61

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	601,601,600.00	596,671,805.00

21	УРСГАЛ ЗАРДАЛ	601,601,600.00	596,671,805.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	601,601,600.00	596,671,805.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	453,980,100.00	453,976,098.00
210101	Үндсэн цалин	291,650,600.00	306,617,771.00
210102	Нэмэгдэл	133,599,300.00	112,398,801.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,742,000.00	13,851,666.00
210104	Урамшуулал	13,988,200.00	21,107,860.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,747,500.00	56,668,118.00
210201	Тэтгэврийн даатгал	38,588,300.00	38,534,087.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,539,800.00	4,533,656.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,631,800.00	3,626,945.50
210204	Ажилгүйдлийн даатгал	908,000.00	906,711.45
210205	Эрүүл мэндийн даатгал	9,079,600.00	9,066,716.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,700,000.00	17,267,571.00
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	4,067,571.00
210302	Түлш, халаалт	12,000,000.00	12,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41,038,900.00	40,824,660.00
210401	Бичиг хэрэг	8,608,000.00	8,234,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,832,900.00	14,179,154.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	14,378,000.00	13,529,106.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	720,000.00	560,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,900,000.00	4,321,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,500,000.00	15,500,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,500,000.00	7,500,000.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	8,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,768,600.00	5,609,000.00
210702	Дотоод албан томилолт	5,768,600.00	5,609,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,366,500.00	2,826,358.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	1,284,312.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,203,000.00	1,378,546.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	67,500.00	67,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00

210807	Газрын төлбөр	52,000.00	52,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4000000.00	4000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	4,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1000000.00	1600000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,600,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	601,601,600.00	596 671 805.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	601,601,600.00	596 671 805.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	601,601,600.00	596 671 805.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,400,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	02.00	02.00
620002	Гүйцэтгэх ажилтан	15.00	15.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	21.00	21.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	09.00	09.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	03.00	03.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	09.00	09.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх нь “ Монгол Улсад хүний эрх эрх чөлөөг хамгаалах хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн хараат бус хариуцлагатай иргэдийн итгэлийн хүлээсэн шүүх эрх мэдлийг төлөвшүүлэхэд оршино” гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2020 оны 76 дугаартай тогтоол, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 06 дугаар сарын 03-ний өдрийн 01/649 дугаартай албан тоотоор тус шүүхийн ажилтны орон тоог ерөнхий шүүгч 1, шүүгч 2, шүүхийн тамгын газар нь 18 орон тоотой, нийт 21 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн Тамгын газар тайлант хугацаанд шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах, шүүх, шүүгчийн аюулгүй байдал, шүүгчийн хараат бус байдлыг ханган ажиллаж, тайлант хугацаанд иргэн аж, ахуйн нэгж байгууллагаас 337 нэхэмжлэл, Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын Прокурорын газраас 67 эрүүгийн хэргийг хүлээн авч анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн байна. Тус шүүхийн эвлэрүүлэн зуучлагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас 90 өргөдөл, хүсэлт хүлээн авч эвлэрүүлэн зуучлагчийн дэмжлэгтэйгээр 78 өргөдөл шийдвэрлэсэнээс 55 нь үр

дүнтэй болж талууд эвлэрсэн байна. Мөн зөрчлийн 183 материал хүлээн авч шийдвэрлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Шүүхийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шүүхийн Тамгын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас хяналтыг 2 жил тутам хэрэгжүүлэн ажилладаг ба төлөвлөгөөт хяналт хийгдэх хугацаа болоогүйтэй холбоотой тус онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29.3 сая төгрөгөөр буюу 0.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	2400.0	2400.0
Авлага	-	-	-
Бараа материал	12454.2	11233.2	1221.0
Үндсэн хөрөнгө	623757.3	593248.4	30508.9
Нийт хөрөнгө	636211.5	606881.6	29329.9
Өр төлбөр	0.6	-	0.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	636205.3	606881.6	29323.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	636211.5	606881.6	29329.9

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 29329.9 мянган төгрөгөөр буурсан материаллаг нөлөө нь мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 631.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 30.0 сая төгрөгөөр бууруулж 601.6 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлангийн хугацаанд тухайн байгууллага нь улсын төсвөөс 601.6 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 596.7 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 4.9 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна.

Бусад төсөл нөөцийн харилцах дансанд ахмадын сангийнд 4,0 сая төгрөгийн орлого орж, гүйцэтгэлээр 1.6 сая төгрөг зарцуулж, ахмадын сангийн үлдэгдэл 2.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг ахлах аудитор Л.Галбадрах 2022 оны 01 дүгээр сарын 27-ноос 01 дүгээр сарын 30-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 15 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 529.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 10.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.4 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүхийн үйл ажиллагаанд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 9 дүгээр зүйлд заасан албан томилот, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэл, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлийн 15.2 -ын зарим заалтууд хамаарахгүй байна.

Тус хуулийн 15.2 зааснаар төсөвт байгууллага сургалт семинар, шүүх хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулснаар, цалин хөлсийг гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгосноор батлагдсан төсвийг 4.9 сая төгрөгөөр хэмнэж дээд шатны байгууллагын дансанд татан төвлөрүүлсэн байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус шүүхийн тамгын газар нь 2022 оны 12 сарын 31 байдлаар төсөв гүйцэтгэлтэй холбоотой 42, Хөрөнгө оруулалт, тендер худалдан авалттай холбоотой 35, бусад мэдээлэл 56, нийт 133 мэдээллийг хуулийн хугацаанд оруулан бүрэн тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас тайлант оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгууллагын түлш халаалтын зардлаас нүүрс худалдан авч ажилчдад түлээ нүүрсний тусламж олгож, түлш халаалтын зардлаар тайлагнасан зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг тайлант онд бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	1785.0	1	1785.0	100
Нийт дүн	1	1785.0	1	1785.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/ алдаа зөрчил илэрсэнгүй.


АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  **У.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР:  **А.ЦЭЦЭГСҮРЭН**

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:  **Д.ГАЛБАДРАХ**





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/20/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2023 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Л.Галбадрах Утас: 99084291 цахим хаяг: L.Galbadrah@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.